

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түүнд хяналт
тавих журмын хэрэгжилт



2016 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Асуудал 1 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хууль журмын дагуу олгогдсон байна..... 5-7
Аудитын менежер О.Амаржаргал	Асуудал 2 Согтууруулуулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлөөс орох орлого хуулийн дагуу төвлөрсөн байна..... 8-9
Аудитор Д.Пүрэвсүрэн Шинжээч Ч.Загдсүрэн	Дүгнэлт 10 Зөвлөмж 11
2016 оны 9 дугаар сарын 12-ны өдөр	Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал 12 Саналд өгсөн тайлбар13
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70272287 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудитор Төндөгийн аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын хэрэгжилтийг шалган дүгнэлт, зөвлөмж, боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ.Үүнд:

- Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хууль журмын дагуу олгогдсон эсэх
- Согтууруулуулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлөөс орох орлого хуулийн дагуу төвлөрсөн эсэх

Аудитыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, сумдын Засаг дарга, холбогдох ажилтнуудын баримт материал, аймгийн ИТХ-аас батласан төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, АДБОУС 4100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль -
- Аймгийн ИТХ-ын 2006 оны 10 дугаар тогтоол, бусад тогтоол, холбогдох журмууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар 2016 оны 7-р сарын 01-нээс 9-р сарын 12-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Асуудал 1

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хууль журмын дагуу олгогдсон байна.

Аудитын зорилт 1 Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хууль журмын дагуу олгогдсон эсэх.

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлийг хууль, журмын дагуу олгон үйл ажиллагаа явуулж байна.

1.1 Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хууль журмын дагуу олгогдсон уу?

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Аймаг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяа нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсаны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно” гэж заасны дагуу аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2006 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтаар “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус журмаар согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх, худалдаж үйлчлэх цагийн хуваарь зэргийг зохицуулсан байна.

Журманд Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар олгох бөгөөд зөвшөөрөл авахад

- Согтууруулах ундаа худалдаж түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгуулах тухай сумын Засаг даргын албан бичиг
- Аж ахуйн нэгжийн албан тоот, иргэн бол хувийн өргөдөл
- Ажлын байрны дүгнэлт
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар нотариатаар батлуулсан эсвэл иргэний үнэмлэхийн хуулбар
- Дэлгүүрийн схем зураг, үйлчилгээний газрын товч танилцуулга зэрэг баримт бичгийг тус тус бүрдүүлэхээр заасан байна.

Зөвшөөрлийн хугацааг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн дагуу жураманд хоёр жилийн хугацаагаар олгохоор заасан байна.

Аймгийн нутаг дэвсгэрт 2015 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргын захирамжаар 554 аж ахуйн нэгж, иргэн хуулийн эдгээдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг дээрх хууль, журмын дагуу олгосон

байна. Үүнийг тодруулбал: 27 суманд 433 худалдах зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээд хүнсний дэлгүүр, 121 үйлчлэх зөвшөөрлийг зоогийн газар 73, ресторан 14, баар, кафе 34-ийг авч нийт 554 цэгт үйл ажиллагаа явуулж байна.

2016 оны эхний хагас жилд шинээр худалдах зөвшөөрөл 19, үйлчлэх зөвшөөрөл 11 иргэн, хуулийн этгээдэд хууль журмын дагуу олгосон байна.

Согтууруулах ундаа худалдах буюу түүгээр үйлчлэх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг сумдаар нь авч үзвэл 10 хүртэл худалдаа, үйлчилгээний зөвшөөрөлтэй 12 сум, 10-20 хүртэл худалдаа, үйлчилгээний зөвшөөрөлтэй 7 сум, 20-50 хүртэл худалдаа, үйлчилгээний зөвшөөрөлтэй 6 сум, 80-112 худалдаа, үйлчилгээний зөвшөөрөлтэй Заамар, Зуунмод сумд байна.

Хамгийн цөөн буюу 3-7 зөвшөөрөлтэй Алтанбулаг, Дэлгэрхаан, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянцогт, Өндэрширээт сумд байхад хүн амын тоо, зам харилцаа, аялал жуулчлалын байршлаас шалтгаалан Баянчандмань, Борнуур, Эрдэнсант сум 27-28, Батсүмбэр сум 34, Эрдэнэ сум 43, Заамар сум 80, Зуунмод сум 112 цэг салбар тус тус согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2013 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 80 дугаар тогтоолоор аймгийн нутаг дэвсгэрт сар бүрийн 01-ний өдөр согтууруулах ундаа худалдахгүй, түүгээр үйлчлэхгүй байхаар тогтоосон байна. Мөн согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх цагийн хуваарийг өглөө 06 цагаас орой 00 цаг хүртэл ажиллуулахаар тогтоосон байна.

2005 оны Үйлдвэр худалдааны сайдын 110-р тушаалаар аймгийн төвийн суманд 2000 хүн ам тутамд согтууруулах ундаагаар үйлчлэх нэг, худалдах нэг цэг, бусад сумдад тус бүр нэг, нэг цэгтэй байхаар тогтоосон нь манай аймагт хэрэгжүүлээгүй буюу хэрэгжих боломжгүй байгаа байдлыг холбогдох байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журмыг “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулинд орсон зарим өөрчлөлт болон “Архидалтын эсрэг - Төв аймаг” /2014-2018/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, заалтанд нийцүүлэн шинэчлэн боловсруулан баталж хэрэгжүүлэх ажил цаг хугацааны хувьд хоцорсон байна.

2015 онд давхардсан тоогоор 698 удаа шалгалт хийгдсэн байна.

1.2 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх, түүнд тавигдаж буй хяналт хууль, журмын дагуу хийгдэж байна уу ?

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журмын 5 дугаар зүйлийн 5.1-5.5-д “аймгийн нутаг дэвсгэр дээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд бүх шатны Засаг дарга, хуулинд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан, улсын байцаагч нар хяналт тавих”-аар заасан байна. Уг журманд “олгосон зөвшөөрлийн үйлчлэх хугацаа хүчинтэй байгаа эсэх, үйлчлэх цэг нь журмын шаардлага хангаж байгаа эсэх, согтууруулах ундаа нь стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэх, холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрх бүхий байгууллага, албан тушаалтан улсын байцаагч зохих хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан байна.

Аймаг, сумдын хяналт шалгалт хийх эрх бүхий хууль хяналтын байгууллагуудын жилийн төлөвлөгөө, “Архины эсрэг-Төв аймаг”/2014-2018/ хөтөлбөрийн хүрээнд болон энэхүү журмын хэрэгжилтэд эрх бүхий байгууллагууд шалгалт хийж байна.

Архи согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл бүхий цэг салбарын үйл ажиллагаанд 2015 онд давхардсан тоогоор 698 удаа шалгалт хийж, хууль хяналтын байгууллагаас 81 иргэн, аж ахуйн нэгжид зөрчил арилгах албан мэдэгдэл өгч, зөрчлийн 85.1 хувийг арилгуулсан байна.

Цагдаагийн байгууллагаас 2016 онд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн холбогдох заалт зөрчсөн 25 зөрчлийг илрүүлж, 25 иргэнийг 615 мянган төгрөгөөр торгож, 2 дэлгүүр, 3 баар, зоогийн газрын согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн байна.

Тус байгууллагын шалгалтаар “Мөнхжин- Од” ХХК, Сангийн далай группын стандартын бус архи үйлдвэрлэж худалдаалахыг завдсан зөрчлийг илрүүлж 324 шил 24300 литр архи согтууруулах ундааг хурааж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.

Мэргэжлийн хяналтын газар нь 2015 онд төлөвлөгөөт хяналт шалгалтаар “Морьтхангай “ХХК-ны архины үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг шалгах” хяналтын хуудсаар үнэлэхэд 47%-тай дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

Зуунмод сумын хувьд жил бүр сумын ЗДТГ-ын ажлын төлөвлөгөөндөө тусган аймгийн ХЭАХНийгэмлэг болон бусад хууль хяналтын байгууллагын улсын байцаагч нартай хамтаран тусгайлан бэлтгэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу шалгалт хийж дүгнэлт, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажилладаг байна.

Асуудал 2

Согтууруулуулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлөөс орох орлого хуулийн дагуу төвлөрсөн байна.

Аудитын зорилт 2 Согтууруулуулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлөөс орох орлого хуулийн дагуу төвлөрсөн эсэх.

Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлийн тэмдэгтийн хураамжаар 2014 онд 49320.0 мянган төгрөг, 2015 онд 34590.0 мянган төгрөг, 2016 оны эхний хагас жилд 30100.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан байна.

2.1 Аймгийн ИТХ-ын тогтоолоор тогтоосон согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж хууль, журмын дагуу төвлөрсөн үү?

Аймгийн ИТХ-ын 2011 оны 09 дүгээр сарын 22-ний 13 дугаар хуралдааны “Тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” 03 тоот тогтоолын 1 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг хүснэгтээр харуулвал:

Тогтоолын заалт	Тусгай зөвшөөрөл олгоход /мян.төг/		Тусгай зөвшөөрлийг сунгахад /мян.төг/	
	Аймгийн төвийн суманд	Бусад суманд	Аймгийн төвийн суманд	Бусад суманд
1.20-д спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	600.0	200.0	200.0	100.0
1.21-д спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах	200.0	100.0	70.0	40.0
1.22-д спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх	800.0	500.0	400.0	200.0
1.23-д спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх	400.0	250.0	200.0	120.0

Энэхүү журмын заалтын дагуу 2014 онд амгийн төвийн 3, сумдын 19 иргэн, аж ахуйн нэгжийн 21 цэг салбарт согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгож 7500.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг, аймгийн төвд 5, сумдад 5 иргэн, аж ахуйн нэгжийн 10 цэг салбарт согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгож 6500.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг, тусгай зөвшөөрлийг сунгахад 35200.0 мянган төгрөгийн нийт 49320.0 мянган төгрөгийн тэмдэгтийг хураамжийг орон нутгийн төсөвт оруулсан байна.

2015 онд аймгийн төвийн 6, сумдын 21 иргэн, аж ахуйн нэгжийн 27 цэг салбарт согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгож 9900.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг, аймгийн төвд 2, сумдад 15 иргэн, аж ахуйн нэгжийн 17 цэг салбарт согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгож 9100.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг, тусгай зөвшөөрлийг сунгахад 14900.0 мянган төгрөгийн нийт 34590.0 мянган төгрөгийн тэмдэгтийг хураамжийг орон нутгийн төсөвт оруулсан байна.

2016 оны эхний хагас жилд 30 цэг салбарт олголт, сунгалт хийж улсын тэмдэгтийн хураамжаар 30100.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан байна.

Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олголт, сунгалтын тэмдэгтийн хураамжийг цэг салбар бүрийн хүчинтэй хугацааг төсвийн орлогын дансны хуулгатай тулгаж үзэхэд Зуунмод сумын Болор дэлгүүр 2015 оны 7-р сард зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан байхад ХБХ-ээс тэмдэгтийн хураамжийн 200.0 мянган төгрөг тушаагдаагүй байхад сунгалт хийлгэсэн байна.

Мөн тус сумын 5-р багийн О.Баасанцэцэг эзэнтэй Далай ээж дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах эрх олгох зөвшөөрлийг 2015.12.23-ний аймгийн Засаг даргын А/548-р захирамжаар олгохдоо тэмдэгтийн хураамжийн 600.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд тушаагаагүй байхад олгосон байна. Энэ нь 2011 оны Аймгийн ИТХ-ын 13 дугаар хуралдааны 03 тоот тогтоолын 1 дүгээр зүйлийн 1-ийн 20 дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Эдгээр зөрчлийг арилгуулан орон нутгийн төсвийн орлогот тэмдэгтийн хураамжийн 800.0 мянган төгрөгийг нөхөж оруулахаар төлбөрийн акт тогтоов.

2.2 Журмын дагуу нэг удаа олгох зөвшөөрлийн гэрчилгээний үнэ журмын дагуу төвлөрсөн үү?

2014 онд 173 гэрчилгээний үнэ 865.0 мянган төгрөг, 2015 онд 92 гэрчилгээний үнэ 460.0 мянган төгрөгийг, 2016 оны эхний хагас жилд 45.0 мянган төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлжээ.

Аймгийн Засаг дарга, Хөгжлийн бодлогын хэлтсээс олгодог Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, тус мөнгөөр гэрчилгээний үнэ буюу шинээр үнэт цаас хэвлүүлэх болон зөвшөөрөлтэй цэг салбаруудын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх шатахуун, томилолтын зардлыг санхүүжүүлэхээр Аймгийн ЗДТГ-ын даргын 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Гэрчилгээний үнийг төвлөрүүлж зарцуулах” тухай А/35 тоот тушаалаар шийдвэрлэн хэрэгжүүлж байна.

2014 онд 173 гэрчилгээний үнэ 865.0 мянган төгрөг, 2015 онд 92 гэрчилгээний үнэ 460.0 мянган төгрөгийг, 2016 оны эхний хагас жилд 45.0 мянган төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, үүнээс гэрчилгээний үнэнд 2014 онд 640.0 мянган төгрөг, 2015 онд 300.0 мянган төгрөгийн зарлага гаргаж, тусгай зөвшөөрөл бүхий худалдаа үйлчилгээний цэг салбаруудад хяналт үнэлгээ хийх томилолт шатахууны зардалд тус данснаас мөнгө зарцуулаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлийг хууль журмын дагуу олгон үйл ажиллагаа явуулж байгаа боловч “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулинд орсон зарим өөрчлөлт болон 2014 онд батлагдсан “Архидалтын эсрэг-Төв аймаг” /2014-2018/ хөтөлбөрийг хэрэгжүүлэн тус журамдаа өөрчлөлт хийгээгүй байна.
2. Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд хяналт тавих ажил зохих ёсоор хийгдсэн байна.
3. Согтууруулуулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж, тусгай зөвшөөрөл олголт, сунгалтаас орох орлого хууль, журмын дагуу төвлөрүүлсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргад ЗӨВЛӨХ НЬ:

1. Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журмыг “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулинд орсон зарим өөрчлөлт болон “Архидалтын эсрэг - Төв аймаг” /2014-2018/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, заалтанд нийцүүлэн ойрын үед шинэчлэн боловсруулан баталж хэрэгжүүлэх.
2. Шинээр батлагдах журмын хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий цэг салбарыг хамруулан үзлэг тооллого, стандартын шаардлагын дагуу аттестатчилал явуулах.
3. Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журмын хэрэгжилтийн байдал түүний үйл ажиллагааны жил бүрийн тайланг, дотоод аудитын дүгнэлтийн хамтаар аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн хуралд буюу аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж байх.

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л. ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Д.ПҮРЭВСҮРЭН

Ч.ЗАГДСҮРЭН

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал


**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**
41000 Уулунца, Төв аймэг
Утас: 76278622, Факс: 76272277

2016.09.16 № 02/1198
талай _____ тал 20 _____

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Л.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА**

Танай газраас ирүүлсэн "Аймгийн нутаг дэвсгэрт
согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх
зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам"-ын
хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын тайлантай
танилцлаа.

Тус тайланд тусгасан дүнгэлт, зөвлөмжийг
хэрэгжүүлж ажиллах болно.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨРӨНГӨ
БОДЛОГО ТӨЛӨӨЛӨЛТНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  Л.ЖАРГАЛ-ЭРДЭНЭ

02 1198
My doc: -2016 on/ A5 last

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэг салбарын судалгаа

№	Сумын нэр	Нийт цэг салбарын тоо	Үүнээс		Үүнээс			Үүнээс: амралт, аялал жуулчлалын бааз
			Худалдах зөвшөөрөлтэй	Үйлчлэх зөвшөөрөлтэй	Ресторан	Баар, кафе, паб	Зоогийн газар	
1	Алтанбулаг	3	3	-	-	-	-	-
2	Аргалант	17	8	9	2	1	6	5
3	Архуст	9	9	-	-	-	-	-
4	Батсүмбэр	34	29	5	-	4	1	1
5	Баян	16	13	3	-	1	2	-
6	Баяндэлгэр	6	1	5	-	1	4	2
7	Баянжаргалан	6	6	-	-	-	-	-
8	Баян-Өнжүүл	5	5	-	-	-	-	-
9	Баянхангай	9	7	2	-	-	2	-
10	Баянцагаан	11	11	-	-	-	-	-
11	Баянцогт	6	6	-	-	-	-	-
12	Баянчандмань	27	21	6	1	1	4	3
13	Борнуур	27	14	13	2	1	10	6
14	Бүрэн	13	12	1	-	1	-	-
15	Дэлгэрхаан	3	3	-	-	-	-	-
16	Жаргалант	30	26	4	-	3	1	1
17	Заамар	80	63	17	-	8	9	-
18	Лүн	12	10	2	-	-	2	-
19	Мөнгөнморьт	11	9	2	-	1	1	1
20	Өндөрширээт	7	7	-	-	-	-	-
21	Сүмбэр	8	8	-	-	-	-	-
22	Сэргэлэн	12	9	3	-	1	2	-
23	Угтаалцайдам	10	9	1	-	1	-	-
24	Цээл	9	8	1	-	1	-	-
25	Эрдэнэ	43	16	27	7	3	17	19
26	Эрдэнэсант	28	28	-	-	-	-	-
27	Зуунмод	112	92	20	2	6	12	-
Бүгд дүн		554	433	121	14	34	73	38
Тайлант хугацаанд шинээр олгосон		30	19	11	1	3	7	4
Нийт дүн		584	452	132	15	37	80	42

**Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн
хураамжийн тайлан 2014 он**

№	Үйлчилгээний төрөл		Нэгжийн үнэлгээ /мян.төг/		Үйлчлүү - лэгчийн тоо	Төвлөрү үлсэн хураамж	Тайлбар
			Хуулиар	ИТХ-аас тогтоосон			
1	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход	Зуунмод	240,0-600,0	600,0	3	1800,0	
		бусад	120,0-300,0	300,0	19	5700,0	
2	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад	Зуунмод	80,0-200,0	200,0	56	11200,0	
		бусад	40,0-100,0	100,0	170	17000,0	
3	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход	Зуунмод	80,0-200,0	200,0	-	-	
		бусад	40,0-100,0	100,0	-	-	
4	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад	Зуунмод	30,0-70,0	70,0	-	-	
		бусад	16,0-40,0	40,0	-	-	
5	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход	Зуунмод	320,0-800,0	800,0	5	4000,0	
		бусад	200,0-500,0	500,0	5	2500,0	
6	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад	Зуунмод	160,0-400,0	400,0	7	2800,0	
		бусад	80,0-200,0	200,0	21	4200,0	
7	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход	Зуунмод	160,0-400,0	400,0	-	-	
		бусад	100,0-250,0	250,0	-	-	
8	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад	Зуунмод	80,0-200,0	200,0	-	-	
		бусад	50,0-120,0	120,0	1	120,0	
Бүгд дүн					287	49320,0	

**Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн
хураамжийн тайлан 2015 он**

№	Үйлчилгээний төрөл		Нэгжийн үнэлгээ /мян.төг/		Үйлчлүү- лэгчийн тоо	Төвлөрүү л-сэн хураамж	Тайлбар	
			Хуулиар	ИТХ-аас тогтоосон				
1	Спиртийн агууламжтай согтууруулах худалдах зөвшөөрөл олгоход	өндөр	Зуунмод	240,0-600,0	600,0	6	3600,0	
		ундаа тусгай	бусад	120,0-300,0	300,0	21	6300,0	
2	Спиртийн агууламжтай согтууруулах худалдах зөвшөөрлийн хугацааг сунгахад	өндөр	Зуунмод	80,0-200,0	200,0	15	3000,0	
		ундаа тусгай	бусад	40,0-100,0	100,0	73	7300,0	
3	Спиртийн агууламжтай согтууруулах худалдах зөвшөөрөл олгоход	сул	Зуунмод	80,0-200,0	200,0	-	-	
		ундаа тусгай	бусад	40,0-100,0	100,0	-	-	
4	Спиртийн агууламжтай согтууруулах худалдах зөвшөөрлийн хугацааг сунгахад	сул	Зуунмод	30,0-70,0	70,0	-	-	
		ундаа тусгай	бусад	16,0-40,0	40,0	-	-	
5	Спиртийн агууламжтай согтууруулах үйлчлэх зөвшөөрөл олгоход	өндөр	Зуунмод	320,0-800,0	800,0	2	1600,0	
		ундаагаар тусгай	бусад	200,0-500,0	500,0	15	7500,0	
6	Спиртийн агууламжтай согтууруулах үйлчлэх зөвшөөрлийн хугацааг сунгахад	өндөр	Зуунмод	160,0-400,0	400,0	4	1600,0	
		ундаагаар тусгай	бусад	80,0-200,0	200,0	16	3200,0	
7	Спиртийн агууламжтай согтууруулах үйлчлэх зөвшөөрөл олгоход	сул	Зуунмод	160,0-400,0	400,0	-	-	
		ундаагаар тусгай	бусад	100,0-250,0	250,0	1	250,0	
8	Спиртийн агууламжтай согтууруулах үйлчлэх зөвшөөрлийн хугацааг сунгахад	сул	Зуунмод	80,0-200,0	200,0	-	-	
		ундаагаар тусгай	бусад	50,0-120,0	120,0	2	240,0	
Бүгд дүн						155	34590,0	

